

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ХЯНАЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.ГАНТУЛГА 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
Зорилт 1. “Хяналт шалгалтын хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангах”							
1.	Арга хэмжээ 1.1. Салбарын хяналт шалгалтын үйл ажиллагаанд мөрдөх эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалт, хяналтын хуудсыг боловсруулж салбарын сайдаар батлуулах	Шинээр боловсруулж батлуулах баримт бичгийн тоо	1	-	Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтээр Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нийтлэг журамд заасны дагуу 11 дүгээр сарын 10-аас 25-ны хооронд хийж гүйцэтгэнэ. /хугацаа болоогүй/	2025.01.02-2025.12.31	-
2.	Арга хэмжээ 1.2. Сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчдыг мэргэжил, арга зүйн, зохион байгуулалтын удирдлагаар хангах	Зохион байгуулах сургалтын тоо	1	1	Аймгийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн хяналт шалгалтын газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Зэвсэгт хүчний жанжин штабын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын (ахлах) байцаагчид цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын бодлого, чиглэл, хууль эрх зүй, мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар	2025.01.02-2025.12.31	100%

					хангах нэгдсэн арга хэмжээг 2025 оны 04 дугаар сарын 23, 24, 25-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулахад оролцож, санал өгч ажилласан		
Зорилт 2. “Яамны стратеги төлөвлөгөөний зорилт” 8. Эрсдэлд суурилсан салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн найдвартай ажиллагааг хангуулах							
1.	Арга хэмжээ 2.1. Хяналт шалгалтын объектуудад эрсдлийн үнэлгээ хийх	Хяналт шалгалтын нийт объектод эрсдлийн үнэлгээнд хамрагдсан объектын эзлэх хувь	20	20	Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтээр Хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нийтлэг журамд заасны дагуу 11 дүгээр сарын 10-наас 25-ны хооронд хийж гүйцэтгэнэ. /хугацаа болоогүй/	2025.06.30-2025.12.31	-
2.	Арга хэмжээ 2.2. Хяналт шалгалтын үйл ажиллагааны эрсдэлийн үнэлгээг хийж, их, дунд эрсдэлийн ангилалд хамаарах 8 объектуудад төлөвлөгөөт шалгалт хийх улсын ахлах байцаагчидтай хамтран хийж гүйцэтгэх	Хууль сахин мөрдөлтийн хувь /хувь/	78	40	Монгол улсын Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөний , Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/63 дугаар тушаалын хавсралтаар баталсан хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтын дагуу “Скаймедиа корпораци” ХХК-д 09-00/07, “Сансар дижитал” ХХК-д 09-00/08 дугаар төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийг хүргүүлж, хяналт шалгалтыг хийсэн.	2025.01.02-2025.12.31	40%
		Эрсдэл үүсэх магадлал /хувь/	79	40			

3.	Арга хэмжээ 2.3. Гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөр, улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын тайлан мэдээг нэгтгэж, дүн шинжилгээ хийх.	Урьдчилан сэргийлэх шалгалтанд хамруулсан объектын тоо, илрүүлсэн зөрчил, авсан арга хэмжээний хэрэгжилтийн хувь	74	79	Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 09-00/06 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамж, Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/197 дугаар албан томилолтоор ажиллуулах хугацаанд өөрчлөлт тухай тушаалын дагуу 2025 оны 2 дугаар сарын 10-аас 18-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Сэлэнгэ баг, Чандмань-Өндөр сумын Улаан асга баг, Эрдэнэбулган сум, Түнэл сум зэрэг газарт баригдсан үүрэн холбооны дахин дамжуулах станцын байр, харилцаа холбооны цамхаг, тоног төхөөрөмжийн зураг төсөл, угсралтын байдалд үзлэг шалгалтыг хийж гүйцэтгэн холбогдох зураг төсөл, стандарт норм дагуу хийж гүйцэтгэх талаар нийт 6 хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажилласан	2025.01.02-2025.12.31	100%
4.	Арга хэмжээ 2.4. Сансрын холбооны кей юү (КУ) зурвасын технологиор телевизийн олон сувгийг орон даяар дамжуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний хүрээнд тус яамны сайдын 2022 оны 02 сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан "Телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээний хяналтын журам"-ын хоёрдугаар хэсгийн дагуу хяналтын комисс нь МХС ТӨК-ийн Наран станцад байрлах /Монголсат нэтворкс ХХК/ газрын станц дахь тоног төхөөрөмжийн	Гүйцэгсэн хяналт шалгалтын тоо	2	2	Сансрын холбооны кей юү (КУ) зурвасын технологиор телевизийн олон сувгийг орон даяар дамжуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний хүрээнд тус яамны сайдын 2022 оны 02 сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан "Телевизийн олон сувгийн нэвтрүүлгийг орон даяар дамжуулах үйлчилгээний хяналтын журам"-ын хоёрдугаар хэсгийн дагуу хяналтын комисс нь МХС ТӨК-ийн Наран станцад байрлах /Монголсат нэтворкс ХХК/ газрын станц дахь тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа, бэлэн байдалтай танилцаж хэмжилт, шалгалт хийн, үйлчилгээ эрхлэгчээс	2025.01.02-2025.06.30	100%

	үйл ажиллагаа, бэлэн байдалтай танилцаж хэмжилт, шалгалт хийн, үйлчилгээ эрхлэгчээс ирүүлсэн тасалдал, саатлын мэдээ болон гэрээгээр хүлээсэн үүргийг журмын 4 дэх хэсэгт заасны дагуу үнэлж, дүгнэлт хийх				ирүүлсэн тасалдал, саатлын мэдээ болон гэрээгээр хүлээсэн үүргийг журмын 4 дэх хэсэгт заасны дагуу үнэлж, дүгнэлт хийсэн		
5.	Арга хэмжээ 2.5. Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамж боловсруулж батлуулах	Батлуулсан удирдамжийн тоо	1	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/63 дугаар тушаалын хавсралтаар баталсан хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтын дагуу Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 09-00/07 дугаар төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай удирдамж боловсруулж, батлуулсан	2025.01.02-2025.12.31	100%
6.	Арга хэмжээ 2.6. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийх	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/	100	50	Тээврийн цагдаагийн газрын зүүн талд байрладаг 150 айлын 4 орон сууцны дунд татагдсан агаарын багана, кабель унжилт үүссэн талаар Нарны зам СӨХ-ийн гүйцэтгэх захирал Ш.Насанжаргалаас 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр ирүүлсэн хүсэлтийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр тухайн газар МХС ХХК-ний УБХСГ-ын КШ-32 тасгийн ахлах инженер Э.Лхагвасүрэн, кабелчидын хамт шалгаж үзэхэд тухайн хэсэгт байрлах 2 ширхэг агаарын багана, үндсэн кабель шугам нь харилцаа холбооны багана биш бөгөөд унжилт үүссэн кабелиуд нь эрчим хүч, цахилгааных байсан. Тухайн хэсэгт харилцаа холбооны худаг сувагчлал байхгүй, эрчим хүчний багана дээр татагдсан 2	2025.01.02-2025.12.31	100%

					шилэн кабель унжилтгүй, нисэлт нь хэвийн байсан. Тухайн мэдээллийг Нарны зам СӨХ-ийн гүйцэтгэх захирал Ш.Насанжаргалд мэдэгдсэн		
7.	Арга хэмжээ 2.7. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд явуулах, Улсын байцаагчийн шийдвэр үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээллийг шалгах	Зөрчил арилгуулалтын /хувь/	78	79	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хууль, тогтоомжийн хүрээнд явуулах, Улсын байцаагчийн шийдвэр үйл ажиллагаатай холбоотой гомдол ирүүлээгүй байна	2025.01.02-2025.12.31	-
Зорилт 3. “Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”							
1.	Арга хэмжээ 3.1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	ХАСХОМ-ын тайлагналт	1	1	1. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгээ шинэчлэн гаргаж, байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хуулийн хугацаанд тайлагнаж баталгаажуулсан. 2. “Улсын байцаагч нарын хяналтын хуудас бөглөх, холбогдох нотлох баримтыг бүрдүүлэх, баталгаажуулах, хэмжүүрийн төхөөрөмжийн үр дүнг гаргах үйл ажиллагаанд хэрэглэх төхөөрөмж худалдан авах” /ЦХИХХЯ/20250202026/ дугаартай тендерийн сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүнээр орж ажиллахтай холбоотой Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг гаргасан.	2025.01.02-2025.06.31	100%

					3. "Дижитал засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250103059 дугаартай тендерийн сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүнээр орж ажиллахтай холбоотой Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдлийг гаргасан.		
2.	Арга хэмжээ 3.2. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, байгууллагын цахим болон дотоодын ээлжит, ээлжит бус шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажиллах	Тухайн жилд өгсөн үүрэг даалгаврын биелэлт /хувь/	100	100	Тайлант хугацаанд Эрүүл мэндийн яамны 2, Соёл, Спорт, аялал жуулчлалын яамны 1, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 1, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны 4 нийт 8 Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолын төсөлтэй танилцаж хариу саналыг хүргүүлсэн. Мөн /ЦХИХХЯ/20250202026/ дугаартай тендерийн мэдэгдэл албан бичгийг 3 байгууллагад хүргүүлэн ажилласан. 1 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн	2025.01.02-2025.12.31	100%
3.	Арга хэмжээ 3.3. Тайлан мэдээг гаргаж хүргүүлэх	Хэрэгжилтийн хувь	100	50	Тайлант хугацаанд газрын 2025 оын 01, 02 дугаар сар хүртлэх 7 хоногийн тайлан мэдээг нэгтгэсэн	2025.01.02-2025.12.31	100%

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Тендерийн сонгон шалгаруулах үнэлгээний хороонд орж ажиллах	Арга хэмжээний тоо	1	1	"Улсын байцаагч нарын хяналтын хуудас бөглөх, холбогдох нотлох баримтыг бүрдүүлэх, баталгаажуулах, хэмжүүрийн төхөөрөмжийн үр дүнг гаргах үйл	2025.01.02-2025.05.09	100%


					ажиллагаанд хэрэглэх төхөөрөмж худалдан авах” /ЦХИХХЯ/20250202026/ дугаартай тендерийн сонгон шалгаруулах үнэлгээний хорооны нарийн бичгээр ажилласан. Худалдан авах ажиллагааг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 4 дүгээр сарын 03-ны хооронд зохион байгуулан тендерийг хүлээн авч 2025 оны 04 дугаар сарын 17-ны өдрийн А/101 тушаалаар Нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулж, 05 дугаар сарын 09-ний өдөр барааг хүлээн авч гэрээ дүгнэсэн актыг баталгаажуулан хүргүүлсэн.		
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Ажлын хэсэгт орж ажиллах	Арга хэмжээний тоо	-	1	Дэлхийн банкны санхүүжилтээр ЦХИХХЯ-ны “Ухаалаг засаг 2” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Монголын интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах” төслийн гүйцэтгэгчээр Мобинэт ХХК ажиллаж байгаа ба тоног төхөөрөмжийг 2025.06.20-ны өдрийн дотор бүрэн хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Тус төслийн ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах ТНБД-ын 2025.05.06-ны өдрийн А/135 дугаартай ажлын хэсэг байгуулагдсан	2025.04.01-2025.06.30	100%
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Тендерийн сонгон шалгаруулах үнэлгээний хороонд орж ажиллах	Арга хэмжээний тоо	1	1	ЦХИХХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 30-ны А/136 дугаартай тушаалаар батлагдсан "Дижитал засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250103059 дугаартай тендерийн сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан.	2025.05.06-2024.07.01	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
Зорилт 4. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1.	Арга хэмжээ 4.1. Мэдлэг ур чадвараа дээшлүүлэх зорилгоор магистрт дэвшин суралцах	Мэдлэгийн түвшин ахисан эсэх /кредит цаг/	-	9	ШУТИС-ын Менежментийн сургуулийн Маркетинг менежментийн магистрийн ангийн 2025 оны хаврын улирлын хичээлүүдийг үзсэн.	2025.01.02-2025.12.31	100%
2.	Арга хэмжээ 4.2. Төрийн худалдан авах ажиллагааны /А-3/ сургалт хамрагдаж сертификат авах	Сертификат авах	1	1	Төрийн худалдан авах ажиллагааны /А-3/ сертификатыг 2022 оны 01 сарын 31 өдөр 2022/А3-0504 авсан.	2025.01.02-2025.06.01	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Харилцаа холбооны хяналт
хариуцсан мэргэжилтэн
(Албан тушаал)

Г.Гантулга /  /
(Нэр, гарын үсэг)

2025-06-10
(Огноо)